

ЭРТНИЙ ДОРНО ДАХИНЫ УЛСУУДАД ХЭРЭГЛЭЖ БАЙСАН ЦААЗААР АВАХ ЯЛЫН ЗАРИМ УЛАМЖЛАЛ

Б.Амарбаясгалан¹

Эртний Дорно дахины улсуудад (Египет, Вавилон, Энэтхэг, Хятад) эрх зүйн гол эх сурвалж нь зан заншлын хэв хууль байсан бөгөөд ихэнхдээ хаант төрөөс хүлээн зөвшөөрөгдсөн хорио цээрийн дэг ёс, ял цаазын талаарх хааны аман зарлиг, бичээс, тэмдэглэлээс бүрдэж байв.

Өдгөө бидэнд Эртний Дорно дахины дурсгалт бичиг болох Хаммурапийн хууль, Манугийн хууль зэрэг хуулиуд нь бүрэн бүтнээрээ, эсвэл хэсэгчилсэн байдлаар уламжлагдан иржээ.

Эртний улсуудад цаазаар авах ялыг харьцангуй түгээмэл хэрэглэдэг байсны дээр талионы систем буюу цусан өшөө авах явдлаас үүсэлтэй гэж үздэг. Цусан өшөө авах² явдал нь зайлшгүй байсан бөгөөд овог нь хохирсон хүнийхээ өмнөөс заавал өшөө авдаг, хэрэв аваагүй тохиолдолд тухайн хүний сүнс, сэтгэл санаа нь тайвшрахгүй гэж үздэг эртний овгийн заншлын уламжлалтай байсан байна.

Эртний Египетчүүдийн хатуу чанд сахидаг “цогц хууль” болох Маат-ыг зөрчсөн этгээдэд цаазаар авах ялыг оноодог байжээ.³ Эртний Египетэд хаант төрийн байгуулалд халдсаныг хамгийн хүнд гэмт хэрэг гэж тооцон энэхүү ялыг түлхүү ногдуулдаг байв. Хүнд гэмт хэргийн тоонд: урвах, хуйвалдах, бослого үймээн гаргах, төрийн нууц задруулах, ариун шүтээнийг бузарлах, Фараоныг эсэргүүцэн сэргөлдөх зэрэг гэмт хэргүүд орох бөгөөд гэм буруутай этгээдийг шийтгээд зогсохгүй түүний гэр бүлийн бүх гишүүдийг хамтад нь цаазалдаг байжээ. Иргэдийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгт бусдыг санаатай алах, ялангуяа эцгийгээ алсан тохиолдолд хатуу шийтгэл ногдуулах буюу цаазаар авдаг байсан байна. Түүнчлэн хулгай хийх, илбэдэх, ариун амьтдыг алах (муур, шар шувуу), шалиглаж завхайрах зэрэг хэргийг үйлдсэн үед цаазаар авах ялыг ногдуулдаг байжээ.⁴

¹ МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн ахлах багш

² Цусан өшөө авах (эсвэл вендетта, латины “vendetta” үгнээс – “өс хонзон” гаралтай) – овгийн байгуулалд хамаарах эртний шүүн таслах ажиллагааны зарчим юм. Хэрэв хэн нэг нь бусдыг санаатай алсан бол түүний гэр бүл, төрөл, овог, бүлгийн аль нэг гишүүнийг золио болгож алдаг байна. Цусан өшөө авах явдлыг хохирогчийн гэр бүл, төрөл, овог, бүлгийн аль нэг гишүүн гүйцэтгэнэ. Цусан өшөө авах явдал нь эрх зүйн зохицуулалтын ямар нэгэн арга хэрэгсэл байхгүй үе буюу хүй нэгдлийн үед бий болсон бөгөөд эдүгээ Ойрхи Дорнод, Умард Кавказын зарим нэг бүс, Албани болон Өмнөд Италид энэхүү зарчим мөрдөгдсөн хэвээр байгаа гэж үздэг.

³ <http://library.thinkquest.org>

⁴ Батыр К.И. История государства и права зарубежных стран. М., 2004. С.12

Эртний Египетэд цаазаар авах ялыг шатаах, гадаст суулгах, толгойг нь цавчих, тахил өргөх, эсвэл шуудайнд хийн Нил мөрөнд живүүлэх зэрэг аргаар гүйцэтгэдэг байв.⁵

Эртний Хятадад цусан өшөө авах явдал удаан хугацааны туршид оршсоор ирсэн ба эрх баригч хаад, түшмэдийн хоорондын зөрчил тэмцлийн явцад хуучны ёс заншил түрэгдэн шахагдаж, оронд нь цаазлан алах ялыг төрийн оролцоо, хяналтан дор оноож хэрэгжүүлэх болжээ.

МЭӨ XVIII-XII зууны үе буюу Шан-Инь төрийн үед цаазаар авах ялыг айлган сүрдүүлэх зорилгоор хэрэглэдэг байсан байна.

Энэхүү төрийн үед хэрэгтнийг ил гал дээр шатаах, биеийг жижиг хэсэг болгон тасдах, дөрвөн мөч, толгойг нь авах, газарт амьдаар нь булах, гар, хөлийг нь тасдах, нүдийг нь ухах зэргийг хэрэглэдэг байв. Түүнчлэн цаазаар авах ялыг биед нь гэмтэл учруулах аргатай хамтад нь хэрэглэдэг байсан байна.

Шань-Инь төрийн үед бэлэгдлийн шинжтэй ял шийтгэл - “сян”-ийг хэрэглэдэг байсан мэдээ бий. Тухайлбал, хөлийг нь тайрах шийтгэлийг өвдгийг нь хар бэхээр будах, цаазаар авах ялыг захгүй цотон цамц өмсгөх зэргээр сольдог байсан байна. Энэ уламжлал нь гэмт хэрэгтнийг олны өмнө яллах замаар хүмүүжүүлэхийг оролдох эхлэл болсон гэж үзэж болно. Энэхүү бэлэгдлийн шинжтэй ял шийтгэлийн үлдэгдэл нь Чжоу төрийн үеэс уламжилж ирсэн баримтад байдаг ба Хань төрийн үед ч сэргээх тодорхой оролдлогуудыг хийж байсан байдаг.

Чжоу төрийн (МЭӨ XII-МЭӨ 221) үед 500 гаруй гэмт хэрэг тоологдож байжээ. Тэдний тоонд төрийн эсрэг (бослого, үймээн самуун гаргах, хуйвалдах, эзэн хаанаасаа урвах), шашны эсрэг (бөөгийн мөргөл, гудамжинд үнс нурам гаргаж хаях), иргэний эсрэг (бусдыг алах, гэмтэл учруулах), өмчийн эсрэг (хулгай хийх, дээрэмдэх, бусдын малыг нядлах), цэргийн (тогтоосон хугацаанд цугларалтанд ирэхгүй байх, цэргийн сахилгыг мөрдөхгүй байх) гэмт хэргүүдийг хамруулж дийлэнхид нь цаазаар авдаг байв. Чжоу хаанчлалын үед татвар төлөхөөс зайлсхийх, архидан согтуурах тохиолдолд цаазаар авах ялаар шийтгэдэг байв.

Чжоу төрийн Му ваны үе буюу МЭӨ 536 онд хамаарах “Хуулиудын тойм” нэртэй хуульд 5 төрлийн ял цаазыг хэрэглэнэ: “мосин” өтгөн бэхээр нүүрэнд нь тамгалах, шивэх - янз бүрийн 1.000 гэм зэм, “исин” хамрыг нь таслах - 1.000 гэм зэм, “фэйсин” хөлийг нь тайрах - 500 гэм зэм, “чужин” (эрэгтэйчүүдийг хөнгөлөх, эмэгтэйчүүдийг шивэгчин болгох) - 300 гэм зэм, “данисин” толгойг нь таслах - 200 гэм зэмийг тогтоосон байна. Үүн дээр нэмэлт болгож бусад ялыг хамтад нь хэрэглэдэг байв, тухайлбал, нарийн, эсвэл өргөн бүдүүн модоор 100 - 500 удаа цохих (500 удаа бүдүүн модоор цохих нь цаазаар авах ялтай эн тэнцэхүйц байв), боол болгох, торгууль ногдуулах гэх мэт.

Эдгээр ял шийтгэл нь зарим талаар тахир дутуу хүмүүсийн тоог улам нэмэгдүүлсэн боловч гэмт явдал бүрэн арилаагүй байна. Түүнчлэн тухайн алах ялаар шийтгэгдсэн этгээд золио өгч дээрх ял шийтгэлээс мултрах бүрэн боломжтой байв: тухайлбал, өтгөн бэхийн оронд - 100 хуан (зэс мөнгө), гар, хөлний оронд - 200 хуан, доромжилсны оронд - 600 хуан, цаазаар авах ялын оронд - 1.000 хуан өгч байжээ. Гэмт этгээдийг нуусан, гэмт этгээдийг

⁵ <http://library.thinkquest.org>

нууж байгаа тухай мэдэгдээгүй бол гэм буруутай этгээдийг биеийг нь хэсэгчлэн хуваах байдлаар цаазалдаг байжээ.⁶

Цинь (МЭӨ 221-МЭӨ 207 он) улсын хаанчлалын үед айлган сүрдүүлэх нь ял шийтгэлийн үндсэн зорилго нь болж энэ үед цаазаар авах ялыг янз бүрийн аргаар гүйцэтгэж байв. Тухайлбал, гэмт хэрэгтнийг халуун тогоонд чанах, хавиргыг нь гаргаж авах, толгойг нь өрөмдөх зэргээр цаазлан егүүтгэж байжээ.

Нэн эрт үед цаазлан алах ялтай этгээдийн төрөл саданг бүгдийг нь устгадаг байв. Цинь улсын үед төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн бол тухайн ялт этгээдийг цаазлаад зогсохгүй, түүний эцэг эх, эхнэрийн талын 3 үеийг гэсгээдэг байв. Ингэхдээ эхлээд шивэх, дараа нь модоор цохих гэх мэт⁷ аргуудыг хэрэглэж цаазаар авдаг байсан. Харин бусдыг гүтгэж дорожилсон, Эзэн хаанаа хараасан тохиолдолд эхлээд хэлийг нь огтолж байж цаазаар авдаг байжээ.

Ийнхүү цаазлан алах ялыг тухайн ялт этгээдийн гэр бүлд халдаан хэрэглэх, гэм буруугүй тохиолдолд талионы зарчмаар давхар ялын хариуцлага хүлээлгэх тухай ойлголтыг эртний Хятадын эрх зүйд өргөн хэрэглэж байв. МЭӨ III зуунд Хань төрийн (МЭӨ 206-МЭ 220 он) Эзэн хаан гэм буруутай этгээдийн гурван үеийн төрөл саданг цаазлах тухай зарлиг гаргаж байжээ. Зарлигт зааснаар эхлээд тэднийг хар бэхээр тамгала шивж, хамар, хөлийг нь тайрсны дараагаар саваа модоор үхтэл нь цохидог байв. Үүний дараагаар тэдний толгойг тасдан, мах болон ясыг нь хар зах дээр хэсэгчлэн хаядаг. Энэхүү ялыг тэдний насны байдлыг үл харгалзан гэм буруутай этгээдийн эцэг эх, үр хүүхэд, ах, эгч, дүү нарт нь халдаан хэрэглэдэг байв. Бага насны хүүхэд байтугай өтөлсөн ахмад настныг ч үл харгалзан зовоон тарчлааж цаазалдаг байжээ. Бусад тохиолдолд гурван үе гэдэг ойлголтыг өргөн хүрээнд хэрэглэж, зарим тохиолдолд гэм буруутай этгээдийн эхнэрийн төрөл саданг ч адил ялаар шийтгэж байв.

Цаазлагдсан этгээдийн бие болон толгойг олон нийтэд үзүүлэхээр хээр, эзгүй тал газар болон хар зах дээр орхидог байжээ. Эзэн хааны дэргэд томоохон албан тушаал эрхэлж байсан хүний толгой, биеийг ордны гадаа өлгөдөг байсан тухай баримт бий.⁸

Эртний Энэтхэгийн эрүүгийн эрх зүйн эх сурвалж нь зан заншил байв. Төр хөгжих тусам эзэн хааны гаргаж байсан хууль нь илүү нөлөөтэй болж ирсэн бөгөөд Эртний Энэтхэгийн эрүүгийн эрх зүйд шашны нөлөө нэн хүчтэй байснаараа онцлог юм.

Эртний Энэтхэгт хүмүүсийн амьдралын өдөр тутмын (дхарм) үйл хөдлөлийг тодорхойлсон хэм хэмжээнүүд дхармашастра хэмээх эмхтгэлд агуулагдаж үлдсэн байдаг. Эдгээрээс бидэнд хамгийн ихээр мэдэгдэж буй дхармашастра нь МЭӨ III-МЭӨ II зуунд хамаарах Манугийн⁹ хууль юм.

Манугийн хуульд тусгасан эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнүүдийг харвал нэг талаас тухайн үедээ хөгжлийн арай өндөр түвшинд байсан гэж үзэхээр, нөгөө талаас талионы зарчмыг хадгалсан хэвээр байсан гэж үзэж болохоор ажээ. Цусан өшөө авах талаар

⁶ *История государства и права в зарубежных странах. Т.1. Под ред. О.А.Жидкова и Н.А.Крашениниковой. М., 2003. С.59*

⁷ *Мөн тэнд*

⁸ *История государства и права в зарубежных странах. Т.1. Под ред. О.А.Жидкова и Н.А.Крашениниковой. М., 2003. С.59*

⁹ *Ману нь домогт гардаг Бурханы нэр юм. Манугийн хууль нь МЭӨ I зуунд зохиогдсон гэж үздэг.*

хуульд дурьдагдаагүй ба энэ нь тухайн үед үүнийг хэрэглэхээ аажмаар хязгаарлаж, улмаар бүрмөсөн больсонтой холбоотой.

Манугийн хууль нь тухайн цаг үеийн нийгэмд эрх баригч бүлэг, хэсгийн эрх ашиг, эрүүл мэнд, амь нас, өмч хөрөнгийг хамгаалах зорилготой байв.

Цаазын ялыг тогтоохдоо хэргийн хүнд, хөнгөн байдал, хохирогч болон гэмт хэрэгтэн ямар варнад¹⁰ хамаарч байгааг харгалзан үздэг байсан: тухайлбал, доодсыг гишгэж байгаа этгээдийг хүлцэнгүй, дээдэст халдсан этгээдийг хайр найргүй гэсгээх гэх мэт. Харин адил төст гэмт хэрэгт дээд варны төлөөлөгчид бага буюу хөнгөн хариуцлага хүлээдэг байсан.

Манугийн хуульд дурьдагдсан гэмт хэргүүдээс эхний байранд төрийн, Эзэн хааны эсрэг хэргүүд орж байсан боловч ийм төрлийн гэмт хэргийн бүрэн жагсаалт (Эзэн хааны дайсанд алба хаах, үйлчлэх, хотын хана, хаалга, хэрмийг эвдэж гэмтээх), тэдгээрт ногдуулах ялын талаар тодорхой заагаагүй байна. Мэдээж эдгээр гэмт хэргүүдэд цаазаар авах ял ногдуулдаг байсан нь тодорхой байна.

Манугийн хуульд Эзэн хааны болон сүм хийдийн эрх ашгийг хөндсөн гэмт хэрэгт хатуу цээрлэл үзүүлдэг байжээ. Тухайлбал, Манугийн хуулийн IX бүлгийн 280 дугаар зүйлд: хааны сан хөмрөг, зэвсэг, сүм хийд, заан, адуу, морин тэрэг зэргийг хулгайлсан бол нэн даруй цаазаар авна гэжээ.¹¹

Манугийн хууль иргэдэд халдсан аливаа хүчирхийллийг чанга хатуу шийтгэдэг байсан бөгөөд хүчирхийлэгчийг хамгийн адгийн хүн хэмээн үзэж, жигшүүлдэг байв. Хүчирхийлэлд бусдыг алах гэмт үйлдэл багтдаг байсан ба гэмтэнд цаазаар авах ял оногдуулдаг байжээ. Өөрийгөө хамгаалах, эмэгтэйчүүд, брахман¹² (аргагүй хамгаалалат) хамгаалахдаа бусдыг алсан бол шийтгэгддэггүй байв. “Алуурчныг илээр болон нууцаар алах явдал нь хэзээ ч алж байгаа хүнд нь нүгэл гэж тооцогддоггүй” гэж IX бүлгийн 351 дүгээр зүйлд заасан аж. Хамгийн хүнд гэмт хэрэгт брахманыг алах явдал байдаг ч брахман хүн бусдын амийг санаатай алсан ч цаазаар авах ялаар шийтгүүлдэггүй байна. Харин үүний оронд улс орноосоо хөөгддөг байжээ.¹³

Эд хөрөнгийн гэмт хэрэг дотроос хулгайн гэмт хэрэгт ихээхэн анхаарлаа хандуулж, хатуу шийтгэдэг байсан байна. Манугийн хуульд хулгайчид ямар хариуцлага хүлээлгэх нь гэмт хэрэгтэн гэмт үйлдэл дээрээ баригдсан эсэх, шөнө, өдөр үйлдсэн зэргээс шалтгаалж янз бүр байв. Гэмт хэрэг үйлдсэн газарт нь гэмт хэрэгтэнг барьсан тохиолдолд шууд цаг алдалгүй ална. Хулгайлсан эд зүйл болон хулгай хийхэд ашигласан зэвсэг хэрэгсэлтэйгээ баригдвал газар дээр нь ямар нэгэн эргэлзээгүйгээр нэн даруй цаазлана. Шөнийн цагт бусдын байранд орж хулгай хийсэн этгээдийн 2 гарыг нь тасдан, гадаст суулгана.¹⁴ Хулгайн гэмт хэрэгт эхний удаа хулгай хийсэн бол гэмт этгээдийн 2 хурууг нь огтлоно, хоёр дахь

¹⁰ Варн гэдэг нь 4 язгуур угсааг илэрхийлдэг: брахман, кишатри, вайшьи, шудр. Хүний биетэй харьцуулвал брахман хүний сахлаас, кишатри гарнаас, вайшьи гуянаас, шудр хөлнөөс гаралтай гэж үздэг байв.

¹¹ Өлзийсайхан Л. Дээж бичиг (эрх зүйн түүх). УБ., 2004. 72 дах тал

¹² Брахман нь нийгэмд хамгийн өндөр байр суурийг эзлэх ба нэгдмэл хүчтэй, хуулийг тайлбарлах монополь эрхтэй, бусад варны төлөөлөгчдөд зөвлөгөө өгдөг. Брахман нь төрийг удирдах хэрэгт идэвхитэй оролцдог. Брахман нь бусад варнд хамаарах төлөөлөгчдөөс хүссэн бүх зүйлээ шаардах эрхтэй. Бүгд түүнд захирагдах ёстой бөгөөд түүний бие халдашгүй байдаг байна.

¹³ Истроия государства и права в средневежных странах. Т.1. Под ред. О.А. Жидкова и Н.А. Крашенинковой. М., 2003. С.52

¹⁴ Өлзийсайхан Л. Дээж бичиг (эрх зүйн түүх). УБ., 2004. 71 дэх тал

удаагаа хулгай хийвэл гар, хөлийг нь тайрана, гурав дахь удаагаа хулгай хийсэн тохиолдолд цаазалдаг байсан байна.¹⁵ Түүнчлэн хулгай хийснийг харсан боловч энэ тухай мэдэгдээгүй байвал яг хулгай хийсэн хүний адил шийтгэдэг байжээ.

Манугийн хуулийн VIII дугаар бүлгийн 323 зүйлд зааснаар язгууртан хүн, ялангуяа эмэгтэйчүүдийн үнэт эдлэл, шүр сувд, эд зүйлсийг хулгайлсан хүнийг цаазаар авдаг байжээ.

Манугийн хуулиар бусадтай самууран шалиглах, эмэгтэйчүүдийн нэр төрд халдах зэрэгт хатуу ял шийтгэл тогтоож байсан. Гэмт хэрэг дотроос шалиглах явдлыг хамгийн нүгэлт хүнд гэмт хэрэг гэж үзэж цаазаар авдаг байв. Манугийн хуулийн VIII дугаар бүлгийн 358 дугаар зүйлд брахман бус хүн эмэгтэй хүнд зөвшөөрөлгүй гар хүрсэн бол шууд цаазаар авна.

Үүнээс гадна худал гэрчлэх, бусдыг гүтгэх, дээд зиндааны хүний үсэнд хүрэх, багш хүүхэд, настай хүн буюу веда заасан брахманыг алахаар завдах, бусадтай явалдсан эр, нуур, цөөрмийн даланг эвдлэн сүйтгэх зэрэгт уг ялыг гүйцэтгэн хэрэгжүүлж байв.

Эртний Энэтхэгт цаазаар авах ялыг янз бүрийн аргаар гүйцэтгэдэг байжээ. Тухайлбал, гадаст суулгах, живүүлэх, ил гал (түүдэг) дээр шатаах, толгойг нь таслах, заанаар гишгүүлэх¹⁶ зэрэг олон аргыг хэрэглэж байсан байна. Мөн гэм буруутай этгээдийн биеийг нь хэсэгчлэх байдлаар цаазаар авдаг байсан.¹⁷ Үүнээс гадна үнэнч бус эхнэрийг нохойгоор дайруулж тасдуулах (VIII, 371), харин түүний хамтрагчийг хайлуулсан төмрөн орон дээр шатаадаг байв.¹⁸ Зарим тохиолдолд өндөр хэмжээний торгууль төлөөд ялаас мултарч болдог байсан байна, өөрөөр хэлбэл 1.000 пан (дундаж нь 500 пан, доод тал нь 250 пан) өгөөд ялаас мултарна гэсэн үг. Энэ нь баян болон ядуу хүнийг тэгш бус, ялгаварлан гадуурхсан байдалд оруулдаг байсан байна. Цаазаар авах тогтоолыг ч цаг алдалгүй нэн даруй гүйцэтгэдэг байжээ.

Эртний Вавилонд Хаммурапи хааны¹⁹ хууль нь МЭӨ XVIII зуунд (1792-1750 онуудад) зан заншлын хууль, Шумер болон Аккадийн хуулиуд дээр тулгуурлан эмхэтгэн боловсруулагдсан, дэлхийн эртний хуулиудын нэг юм.

Хаммурапийн хуульд заасан ял шийтгэлийн төрлүүд нь түүний зорилгоор тодорхойлогдож байсан тул хууль тогтоогч ял шийтгэлийг оноохдоо талионы²⁰ зарчмыг баримталдаг байсан байна.

Талионы зарчмыг ял шийтгэлийг тодорхойлохдоо удирдлага болгодог байв: гэм буруутай этгээд хохирогчид ямар хор хохирол учруулсан яг л тийм хувь зохиол түүнийг хүлээж байв.

¹⁵ Мөн тэнд

¹⁶ Мөн тэнд. 30 дах тал

¹⁷ Графский В.Г. Всеобщая история государства и права. М., 2007. С.103

¹⁸ Истрия государства и права в зарубежных странах. Т.1. Под ред. О.А.Жидкова и Н.А.Крашенниковой. М., 2003. С.53

¹⁹ Хаммурапи (Hammurapi)-МЭӨ XVIII зууны үед амьдарч байсан Вавилоны хаан

²⁰ Талионы зарчим (лат. lex talionis) нь ял шийтгэл нь гэм буруугийн өр төлөөс – хариу авах явдал юм, иймд ял шийтгэл нь үйлдсэн гэмт хэрэгтэй нь «эн тэнцүү» байх ёстой, өөрөөр хэлбэл «нүдийг нүдээр, шүдийг шүдээр» гэдгээр илэрхийлэгдэнэ. Талионы систем нь хэдийгээр арга, агуулга нь өөрчлөгдсөн ч уламжлалт хэв шинжээ бүрэн гээлгүй XIX зууны эхэн хүртэл хадгалагдан хөгжсөөр ирсэн билээ (Европ, Ойрхи Дорнод, Ази)

Бид талионыг зөвхөн харгис хатуу гэдгээр ойлгодог. Гэтэл бүр эртний үед энэ нь ял шийтгэлийг хязгаарлах арай логик арга хэрэгсэл байсан байна: чамд учруулснаас илүү ял шийтгэл оноож болохгүй. Шударга ёсны тухай эртний хүй нэгдлийн ойлголтын үндсэн дээр үүссэн энэхүү ойлголт нь чиний, чиний төрөл, овогт ямар хор хохирол учруулж хүчгүйдүүлсэн байна, дайсныг мөн адил тэгж хүчгүйдүүлнэ гэсэн зарчимтай. Эхний үед энэ нь их энгийн байв. Шинэ Гвинейн нэг омог нь дайтагч хоёр талаас алагдсан хүнийхээ тоог тэнцүүлэх хүртэл дайн хийдэг байсан байна. Шинээр хүний амь нас хохирох бүрт үүнийг тооцоондоо оруулдаг байсан байна. Ийм жишиг, уламжлал эртний Умард Америкийн индиануудад ч тохиолддог байжээ: алагдсан хүмүүсийн тоо тэнцэх хүртэл энх тайван тогтдоггүй байсан.²¹

Хаммурапийн хуульд цусан өшөө авах тухай дурьдаагүй байна. Харин хэд хэдэн тохиолдолд хүй нэгдлийн уламжлал, эртний овгийн байгууллын үлдэгдлийг агуулж байсан нь хатуу ял шийтгэл оноох талионы зарчим зэргээр илэрч байсан бөгөөд энэ нь удаан хугацааны туршид хадгалагдан үлдсэн. Энэхүү талионы зарчмыг зөвхөн санаатайгаар үйлдсэн гэмт хэрэг төдийгүй болгоомжгүй үйлдсэн гэмт хэрэгт ч хэрэглэдэг байв. Тухайлбал, Хаммурапийн хуулийн 229 дүгээр зүйлд “Хэрэв барилгачны барьсан байшин чанарын шаардлага хангаагүйн улмаас нурж эзнийг дарж алах аваас барилгачинг цаазаар авбал зохино”²². Энэхүү зүйл нь барилгачны хайнга байдлыг тогтоож талионы үндсэн дээр шийтгэхээр заасан байна. Дээрх зүйлийн үргэлжлэл болох 230 дугаар зүйлд “Хэрэв байшин нурж эзний хүүг нь алах аваас барилгачны хүүг мөн алваас зохино”²³ гэжээ. Эндээс үзэхэд тухайн гэмт хэрэгтэй ямар ч хамааралгүй буюу холбоогүй, гэм буруугүй этгээдийг хүртэл цаазаар авдаг байсан байна.

Хаммурапийн хуульд гэмт хэргийн бүрэн жагсаалтыг гаргаж өгөөгүй байна, тухайлбал төрийн болон шашны гэмт хэргийн талаар огт дурьдаагүй ч бодит байдал дээр энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байсан гэж үзэх үндэстэй. Эдгээр гэмт хэрэгт оноох ял шийтгэл нь тодорхой байсан тул хууль тогтоогч үүнийг тусгайлан дурьдах нь илүүц гэж үзсэн бололтой.

Хаммурапийн хуульд цаазаар авах ялыг төрийн болон шашны эсрэг гэмт хэргийг оролцуулахгүйгээр 30 гаруй тохиолдолд хэрэглэхээр зааж байсан байна.²⁴

Хаммурапийн хуульд эд хөрөнгийн бүх гэмт хэрэгт (мал, боол хулгайлах, дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг гэмтээх, устгах, залилан мэхлэх зэрэг) хатуу ял шийтгэл оноодог байсан. Нэг бол цаазаар авах, эд эрхтнийг нь гэмтээх (тухайлбал, гарыг нь таслах), эсвэл их хэмжээний торгуулийн арга хэрэглэдэг байв. Энэ торгууль нь хулгайлагдсан зүйлийн үнийн дүнг хэд дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх бөгөөд хэр баргийн хүн үүнийг төлж дийлдэггүй байсан. Торгуулиа төлж чадаагүй бол цаазалдаг байсан байна. Өөрөөр хэлбэл, энэ нь бараг цаазаар авах ялтай дүйцэхүйц байв. Энэ тухай 8 дугаар зүйлд “Хэрэв хэн нэгэн этгээд үхэр юмуу хонь, эсвэл илжиг, мөн гахай ба ямаа хулгайлсан бөгөөд энэ нь сүмийн ба шүүхийнх бол хулгайч түүнийг 30 нугалж төлөх бөгөөд үүнд: хэрэв эдгээр нь эзэн хааны чөлөөт иргэний өмч байсан бол 10 нугалж төлөх, хэрэв төлж барагдуулах мөнгөгүй аваас

²¹ Черниловский З.М. *Всеобщая история государства и права*. М., 2000. С.27

²² Л.Өлзийсайхан. *Дээж бичиг (Эрх зүйн түүх)*. УБ., 2004. 24 дэх тал

²³ Мөн тэнд. 24 дэх тал

²⁴ <http://criminal.findlaw.com>

түүнийг алах ёстой” гэж зааж байжээ.²⁵

Хаммурапийн хуулиар эзэн хааны ордны болон сүмийн өмчийг тусгайлан хамгаалдаг байсан нь уг хуулийн 6 дугаар зүйлд “Хэрэв хэн нэгэн этгээд сүм болон шүүх танхимаас ямар нэгэн юм хулгайлсан бол үхэх ёстой бөгөөд түүнээс уг хулгайлсан юмыг худалдан авсан хүн бас үхэх ёстой”²⁶ гэсэн байна.

Байшингийн хана хэрмийг эвдэн нэвтлэн орж хулгай хийсэн гэмт хэрэгтэнг тэрхүү ханын хажууд газарт булж шийтгэдэг бол гал түймрийн үед хулгай хийсэн бол галд шиддэг байсан байна. Боолыг хулгайлах, оргон зугатаасан үед түүнийг нуух зэрэг тохиолдлыг хүнд гэмт хэрэг гэж тооцдог байсан аж. Боолоос түүний боол гэсэн тэмдгийг хуссан үсчингийн хурууг огтолдог байсан баримт байдаг бөгөөд хэрэв үсчинг тийм үйлдэл хийхэд хүргэсэн этгээдийг цаазаар авдаг байв. Боолыг алсан бол эзэнд нь түүнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг өгдөг ба үүнийг тухайн гэмтэн этгээдээс зохих хувиар гаргуулдаг байв.

Иргэдийн эсрэг гэмт хэрэг дотроос бусдыг санаатай алсан (эхнэр нь нөхрөө бусадтай хуйвалдан алах) тохиолдолд нөхрөө алсан эмэгтэйд шатаадаг байсан ажээ. Болгоомжгүйгээр бусдыг алах гэмт хэрэгт цаазаар авах ял ногдуулж болохоор байсан нь харагдаж байна. Үүнд: барилгачны барьсан байшин нь нурж, үүний улмаас гэрийн эзэн нас барсан бол барилгачныг цаазаар авна.

Харин харилцааны зодооны үед санамсаргүйгээр бусдыг алснаа гарцаагүй баримтаар нотолж чадвал цаазаар авах ялын оронд торгуулийг хэрэглэдэг байсан байна.

Гэр бүлийн эсрэг гэмт хэрэгт эхнэрийн талаас шалиглаж, завхайрах, цус холилдох (тухайлбал, эх нь хүүтэйгээ, эцэг нь охинтойгоо болон бусад ойрын төрөл садантайгаа), хүчиндэх, хүүхдийг хулгайлах, эхнэр нь нөхрөөсөө зугтах, нөхөртэй эмэгтэйд авч явах гэх зэрэгт цаазаар авдаг байжээ. Эдгээр төрлийн гэмт хэрэгт ял шийтгэл оноохдоо гэмт хэрэгтэн, хохирогч нарын зөвхөн нийгмийн байдлыг төдийгүй тэдний хүйс, гэр бүлийн байдал зэргийг харгалздаг байв.

Үүнээс гадна Хаммурапийн хуульд зааснаар бусдыг гүтгэх, худал гэрчлэх, дээрэм хийх, цэргийн албанаас зайлсхийх, цэргийн гэмт хэрэг үйлдэх, хүчирхийлэх, боол хулгай хийсэн бол боолыг зугатахад нь туслах, оргосон боолыг гэртээ орогнуулах, боолыг шилжүүлэн өгөхөөс татгалзах, боолтой худалдах, худалдан авах хэлцэл хийсэн тохиолдолд худалдан авагчийг цаазаар авах ялаар шийтгэдэг байсан байна.

Цаазаар авах ялыг олон нийтийн өмнө янз бүрийн зовоон тарчлаах харгис хэлбэрээр гүйцэтгэдэг: живүүлэх, шатаах, газарт булах, гадаст суулгах гэх мэт. Үүнээс гадна цаазаар авах ялыг гүйцэтгэх зарим онцлог байв. Тухайлбал, бусдын эд зүйлийг хулгайлах зорилгоор байшингийн ханыг нэвтлэн нүх гаргавал яг тэр газар нь булна, хэрэв байшин шатаж байх үед хулгай хийсэн (25 дугаар зүйл), түүнчлэн бусадтай хуйвалдан эр нөхрөө алсан эмэгтэй (153 дугаар зүйл) зэрэг тохиолдлуудад гал руу шидэх болон гадаст суулгадаг байв. Цаазаар авах ялын тогтоолыг цаг алдалгүй, олон нийтийн өмнө гүйцэтгэдэг байв.²⁷

Дээрхээс дүгнэж үзэхэд эртний улсуудад цаазаар авах ял нь дараах зорилгыг гүйцэтгэж байсан гэж үзэхээр байна.

²⁵ Мөн тэнд. 9 дэх тал

²⁶ Мөн тэнд.

²⁷ История государства и права древнего мира и средних веков. Кучма В.В. Волгоград. 2004. С.81

Нэгдүгээрт, ард иргэдийг айлган эмээлгэхэд чиглэгдэж байсан бөгөөд ингэхдээ цаазаар авах ялыг аль болох зовоон тарчлаах шинжтэйгээр гүйцэтгэдэг байсан байна. Түүнчлэн тухайн гэмт хэрэгт ямар ч хамааралгүй, гэм буруугүй (эцэг эх, үр хүүхэд, төрөл садан гэх зэрэг) хүмүүсийг цаазаар авдаг байв.

Хоёрдугаарт, дээрхтэй холбоотойгоор бусад этгээдүүдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хүмүүжүүлэхэд оршиж байсан. Иймд эртний үед бараг бүх тохиолдолд цаазаар авах ялыг илээр буюу олон нийтийн өмнө гүйцэтгэдэг байжээ. Тухайн арга хэмжээнд оролцож байгаа ард иргэд нь хүний цусанд яваандаа дасч, цаазаар авах ялыг гүйцэтгэх ажиллагаа нь үзвэр мэт болж ирсэн билээ. Тухайлбал, Эртний Ромд цаазаар авах ялыг театрын талбар болгон, гладиаторуудын тэмцэл болгосон байна. Үзэгчид энэ үед гар, хуруугаа өргөж, эсвэл буулгаснаар нэг ёсондоо цаазаар авах ялын дам гүйцэтгэгч нар болж хувирдаг байсан байна.

Бүхэлд нь дүгнэж үзвэл Эртний Дорно дахины улсуудын хэрэглэж байсан цаазаар авах ял нь ялын дээд хэмжээний анхны үр үндэс нь болсон бөгөөд дараагийн үед уг ялын зорилго, үндэслэл нь улам боловсронгуй болж, түүний арга, төрөл, агуулга нь өөрчлөгдөж ирсэн ч тухайн цаг үеийн уламжлалт хэв шинж, уг гарвал нь цаазын ялын мөн чанарыг тодорхойлоход анхдагч хүчин зүйл болсоор ирснийг үгүйсгэх аргагүй.